



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 65 дугаар цэцэрлэгийн  
эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,400,000 (найман сая дөрвөн зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 65 дугаар цэцэрлэг (Б.Баярмаа)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг (Ч.Янжиндулам)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

*Б.Оюумаа* В.ОЮУМАА



1150500055

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2024 оны 02 дугаар сарын 15 ний өдрийн  
А/16 дугаар тушаалын хавсралт



### Хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 65 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ (төгрөгөөр)		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
						Нэгж үнэ	Нийт үнэ			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Хүүхдийн сандал	2022.03.01	сайн	ш	120	40,000.00	4,800,000.00	640,000.00	4,160,000.00	145 дугаар цэцэрлэг
2	Хүүхдийн ширээ	2022.03.01	сайн	ш	15	240,000.00	3,600,000.00	480,000.00	3,120,000.00	
Шилжүүлэх хөрөнгийн дүн					135		8,400,000.00	1,120,000.00	7,280,000.00	
Нийт дүн							8,400,000.00	1,120,000.00	7,280,000.00	